



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 26

Номгон

Өхэг амралтын газрын менежментийн хувьчлал
болон 2009-2016 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт
хийж, дүгнэлт гаргах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.11 дэх заалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Галуут сумын нутагт орших Өхэг амралтын газрын менежментийн хувьчлал
болон 2009-2016 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлын
хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Э.Энхбат-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
төлөөлөгч, Тэргүүлэгч

Гишүүд: Ж.Хүрэлбаатар-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч,
Тэргүүлэгч

С.Цэгмид-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Л.Доржханд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Д.Содномсамдан-Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
мэргэжилтэн

Ц.Пүрэвсүрэн-Аймгийн Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын
захиргааны Хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт, орчны бүс хариуцсан мэргэжилтэн

2. Ажлын хэсгийн дүгнэлтийг 2017 оны 03 дугаар сарын 15-ны дотор аймгийн
иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлэхийг ажлын
хэсгийн ахлагч /Э.Энхбат/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

116003